



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот


Журам батлах тухай

“Аудитын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтын журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Бусад орны мэргэшсэн нягтлан бодогчийн эрхтэй иргэнд мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох журам”-ыг 2 дугаар хавсралтаар, “Мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээ”-г 3 дугаар хавсралтаар, “Хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээ”-г 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Санхүү, эдийн засгийн сайдын 2006 оны 135 дугаар тушаал, “Журамд өөрчлөлт оруулах тухай” 2011 оны 101 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Энэ журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /С.Мягмардаш/-т үүрэг болгосугай.



Д.ХАЯНХЯРВАА

000314

Сангийн сайдын 2012 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 33 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтын журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, сунгах шалгалт /цаашид шалгалт гэх/-ыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтыг Сангийн сайдын тушаалаар байгуулагдсан шалгалтын комисс Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт /цаашид институт гэх/-тэй хамтран зохион байгуулна.

1.3. Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох сургалтын хөтөлбөрийг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан боловсролын стандартад нийцүүлэн боловсруулж мөрдөнө.

1.4 Аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5 дахь заалтын дагуу мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хугацаагүй олгоход энэхүү журмын холбогдох заалтыг баримтална.

2 дугаар зүйл. Мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтын бүртгэл

2.1 Аудитын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан иргэн мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтыг өгч болно.

2.2. Мэргэжлээрээ ажилласан гэдэгт нягтлан бодогчоор эсвэл нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг хянах, шалгах үүрэг бүхий албан тушаалтан, багш нарыг хамруулна.

2.3 Нягтлан бодогчоос бусад мэргэжил эзэмшсэн иргэн Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад орохын тулд институтэд мөрдөж байгаа хөтөлбөрийн дагуу сургалтанд хамрагдаж, шалгалт өгч тэнцсэн талаар нотолгоотой байна.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бакалаврын сургалтын хөтөлбөр дэх мэргэжлийн хичээлийн 33 кредит цагаас доошгүй байна.

2.5 Иргэн шалгалтанд дараах баримт, материалыг бүрдүүлж бүртгүүлнэ. Үүнд:

- 2.5.1 иргэний үнэмлэх, нотариатаар батлуулсан хуулбарын хамт
- 2.5.2 шалгалтанд орохыг хүссэн өргөдөл
- 2.5.3 анкет
- 2.5.4 ажилладаг байгууллагын тодорхойлолт
- 2.5.5 төгссөн сургуулийн дипломын нотариатаар батлуулсан хуулбар
- 2.5.6 3 хувь зураг
- 2.5.7 нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар батлуулсан хуулбар
- 2.5.8 энэ журмын 2.3-д заасан сургалтын шаардлага хангасан нотолгоо, сертификат

2.5.9 шалгалтын төлбөр төлсөн баримт

2.6 Шалгуулагчийн шалгалтын төлбөрийн хэмжээг холбогдон гарах зардлын хэмжээг үндэслэн институт тогтооно.

2.7 Шалгалтын бүртгэлийн хугацаанд бүртгэлээ цуцлах тохиолдолд шалгалтын хураамжийн 50 хувийг эргүүлэн олгох ба бүртгэл дууссаны дараа ямар нэгэн шалтгаанаар шалгалтанд ороогүй тохиолдолд шалгалтын хураамжийг эргүүлэн олгохгүй, бусдад шилжүүлэн тооцохгүй болно.

3 дугаар зүйл. Мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтыг зохион байгуулах

3.1 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтыг Сангийн сайдын тушаалаар батлагдсан зохион байгуулах комисс институттэй хамтран Улаанбаатар хотод жилд 2 удаа, аймгуудад нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

3.2 Улаанбаатар хот болон орон нутагт явагдах шалгалтын хугацааг Институтээс шалгалт эхлэхээс нэг сарын өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

3.3 Орон нутагт явагдах шалгалтыг жилд 1-2 удаа аймгуудыг бүсчлэн нэгэн зэрэг явуулах ажлыг шалгалтын комисс зохион байгуулна.

3.4 Шалгалтын комисс нь тухайн жилд орон нутагт зохион байгуулах шалгалтын хуваарийг оны эхэнд Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар батлуулна. Хуваарьт шалгалт авах өдөр, цаг, зохион байгуулах газрыг тодорхой заасан байна.

3.5 Шалгалтанд орох хүмүүсийн бүртгэлийг баталсан маягтын дагуу нийслэлд институтын шалгалтын зохион байгуулалтын дэд хороо, орон нутагт аймаг, хотын Засаг даргын тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн болон институтийн салбар бүртгэнэ.

3.6 Шалгалт зохион байгуулах аймгийн санхүү, төрийн сангийн хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн нь шалгалтанд орох хүний урьдчилсан тоог шалгалт эхлэхээс 10 хоногийн өмнө шалгалтын комисст албан бичгээр ирүүлнэ.

3.7 Шалгалтын комисс нь орон нутгийн шалгалтын материалыг шалгалт авах өдрөөс 2 хоногийн өмнө бэлтгэж, битүүлжилнэ.

3.8 Орон нутагт явагдах шалгалтыг тухайн аймаг, хотын Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтэс шалгалтын комиссын гишүүнтэй хамтран тогтоосон хуваарийн дагуу зохион байгуулна.

3.9 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад орох болзлыг хангасан аймаг орон нутгийн харьяалалтай хүн хүсвэл Улаанбаатар хот болон бусад аймагт шалгалт өгч болно.

3.10 Улаанбаатар хотын харьяалалтай иргэн зөвхөн Улаанбаатар хотод зохион байгуулагдах шалгалтанд орно.

4 дүгээр зүйл. Шалгалтыг зохион байгуулах комиссын эрх, үүрэг

4.1 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг тухайн жилд томилно. Комисс нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, 7 гишүүнээс бүрдэнэ. Комиссын дарга нь Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын асуудал хариуцсан нэгжийн дарга байна.

4.2 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, сунгах шалгалтын комиссын бүрэлдэхүүнд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас 4, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтээс-3, бусад байгууллагаас 3 хүний төлөөлөл байна.

4.2 Шалгалтын комиссын гишүүдийн гүйцэтгэх ажил үүрэг болон шалгалтын материалыг шифрлэх, засах хуваарийг шалгалтын комиссын дарга зохион байгуулна.

4.3 Шалгалтын материалыг сонгогдсон тестийн эх хувийг шалгалтын комиссын дарга хадгална.

4.4 Комиссын гишүүд нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр шалгалт авах ажлын туршлагатай байна.

4.5 Шалгалтын комиссын дарга, гишүүд дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

4.5.1 Тестийн санд нэвтрэх код, багцалсан тестийн материал зэргийг шалгалтын комиссын даргын шийдвэрээр комиссын гишүүн хадгалах;

4.5.2 Мэдээллийн санд хангалттай тест бүрдсэн нөхцөлд түүнээс шалгалтын тестийг санамсаргүй түүврийн аргаар сонгож бэлтгэх, нууцлалыг хадгалах;

4.5.3 Шалгалтын явцад хяналт тавих, хяналтыг үр өгөөжтэй дэвшилтэт арга, хэлбэрээр зохион байгуулах;

4.5.4 Шалгалтыг шудрага, ил тод байлгах зорилгоор шалгалтын материалыг засах, нэгтгэхэд хамгийн сүүлийн үеийн техник, технологи ашиглаж нийтэд мэдээлэх;

4.5.5 Шалгалтын комиссын даргын томилсон гишүүн шалгалтын тестийг хувилан анги тус бүрээр тоолж дугтуйлан битүүмжлэх;

4.5.6 Шалгалт эхлэхэд комиссын гишүүд шалгалтын тестийн битүүмжлэлийг шалгуулагчдаар магадлуулж задлах;

4.5.7 Шалгалтын комиссын ба ажлын хэсгийн гишүүд шалгалтын тесттэй холбогдох асуудлыг нийтийн өмнө тодруулахаас өөрөөр шалгуулагчидтай харилцахыг хориглоно;

4.5.8 Шалгалтын комиссын ба ажлын хэсгийн гишүүд нь шалгуулагчид хоорондоо харилцах, ямар нэгэн холбооны хэрэгсэл ашиглах, материал хуулах зэрэг зөрчил гаргуулахгүйгээр шалгалтыг хянана. Зөрчил гаргасан шалгуулагчийг протоколд тэмдэглэн шалгалтын танхимаас гаргах эрхтэй;

4.5.9 Шалгалтын материалыг битүүмжилэн институтийн шалгалтын хорооны даргад шалгалтын комиссын гишүүд өөрийн биеэр хүлээлгэн өгөх;

4.5.10 Шалгалтын комиссын дарга, гишүүд шалгалтын дүнг хөдөлгөх буюу засахыг хориглоно;

4.5.11 Шалгалтын комиссын дарга, орлогч дарга зөвшилцөн орон нутгийн шалгалт авах хүнийг комиссын гишүүдээс томилно.

4.6 Шалгалтын материал ба хариултын хуудсыг тарааснаас хойш шалгалтын анги танхимд хүн орж, гарахыг хориглоно.

4.7 Шалгалтын тестыг засагдсаны дараа нууц кодыг хөрвүүлж шалгуулагч бүрээр дүнг гаргана.

5 дугаар зүйл. Эрх олгох, сунгах шалгалтын үед институтын хүлээх үүрэг

5.1 Улаанбаатар хотод шалгалтанд орох иргэнийг интернет болон тусгайлан эрх олгосон бүртгэгчид биечлэн бүртгэнэ.

5.2 Шалгалтанд орох хүмүүсийг бүртгэх үйл ажиллагааг шалгалт эхлэхээс 48 цагийн өмнө тасалбар болгоно.

5.3 Шалгалтын комиссын гишүүдэд комиссын хуралдаан, шалгалтын материал бэлтгэх, шалгалт авах, материалыг засах, дүнг нэгтгэн гаргах зэрэг ажилласан цагийн тооцоог комиссын даргаар батлуулан нэг цагийн урамшууллыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 10 хувиар тооцон институтээс олгоно.

5.4 Хөдөө орон нутагт ажилласан комиссын гишүүдийн томилолтын зардлыг тухайн үед мөрдөж байгаа улс төрийн болон төрийн захиргааны албан хаагчийн албан томилолтын зам хоног, байрны зардлын хэмжээг 1,5 дахин өсгөсөн дүнгээр тооцож институтээс олгоно.

5.5 ММНБИ нь шалгалтын дараа дараах материалыг бүрдүүлэн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд ирүүлнэ. Үүнд:

5.5.1 Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, эрхийн хугацаа сунгах шалгалтад тэнцсэн иргэний овог нэр, шалгалтын дүнгийн жагсаалтыг шалгалтын комиссын гишүүдээр баталгаажуулсан байдлаар

5.5.2 Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай” 199 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, эрхийн хугацаа сунгах шалгалтад тэнцсэн иргэний улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтын хуулбар хувь, төлсөн татварийн хэмжээг нэгтгэсэн жагсаалтын хамт тус тус ирүүлнэ.

5.6 Эрх олгох шалгалтад тэнцсэн мэргэшсэн нягтлан бодогчоор тангараг өргүүлэх ёслолын ажиллагааг институт зохион байгуулна.

5.7 Шалгалт авах анги, танхимыг /гар утасны долгион барихгүй байх боломжийг бүрдүүлэх/ бэлтгэнэ.

5.8 Институт нь мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, сунгах шалгалтад зориулж зохих хичээл бүрээр мэдээллийн санг бүрдүүлсэн байна.

5.9 Институт нь мэдээллийн сангийн иж бүрдэл болон үнэн зөв байх үүргийг хүлээнэ.

5.10 Шалгалтын материалыг институт 6 сарын турш хадгална.

5.11 Шалгалт авах үйл ажиллагаанд шалгалтын комиссын даргатай зөвшилцөн институтын гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг тусалж болно.

5.12 Ажлын хэсэгт шалгалтын үйл ажиллагаанд хяналт тавих дадлага туршлагатай / институтын багш, ажилчид болон их дээд сургуулийн нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн багш нараас бусад/ 15 хүртэлх хөндлөнгийн хүнийг оролцуулж болно.

5.13 Ажлын хэсгийн гишүүд шалгалтын комисст шалгалтын тестийг олшруулахад туслаж болно.

5.14 Ажлын хэсэг нь шалгалтын анги танхимын бэлтгэл ажлыг хангах, суудлын дугаарыг тавих, шалгуулагчийг бүртгэх, шалгалтын явцад шалгуулагчдад хяналт тавина.

6 дугаар зүйл. Шалгуулагчийн хүлээх үүрэг, хариуцлага

6.1 Шалгуулагч шалгалтын байранд шалгалт эхлэхээс 30 минутын өмнө ирсэн байх шаардлагатай бөгөөд шалгалт өгөх анги, танхимд 10 минутын өмнө суудлаа эзэлсэн байна.

6.2 Энэхүү журмын 6.1-д заасан хугацаа (цаг, минут)-аас хоцорсон шалгуулагчийг шалгалтад оруулахгүй.

6.3 Шалгалтын анги танхимд гар утас, томъёоны хураангуй, ном, дэвтэр, ноорог цаас, гарын авлага, цаасан болон электрон толь бичиг, компьютер MP3, MP4, дуу хураагуур болон бусдад саад болох, хууран мэхлэх ямарваа нэгэн зүйлийг авч орохыг хориглоно.

6.4 Хариултын хуудсыг санамжийн дагуу хар өнгийн харандаагаар, бодолттой даалгаварыг хар ба хөх өнгийн үзгэн болон тосон балаар тод засваргүй бөглөнө.

6.5 Шалгуулагч биеийн эрүүл мэндийн байдлаас болон бусад шалтгаанаар шалгалтын анги, танхимаас гарсан бол шалгуулагчийн гарах хүртлээ хийсэн даалгаврыг дүгнэж зохих оноог өгнө.

6.6 Шалгуулагч шалгалтын даалгаврыг гүйцэтгэхдээ бусдаас дэмжлэг авсан, энэхүү журмын 6.3-д хориглосон зүйлийг ашигласан, бусдад тусласан, хоорондоо

ярилцах зэргээр бусдад саад учруулсан бол шалгалтын журам зөрчсөнд тооцож, тухайн шалгалтын материалыг хүчингүй болгоно.

6.7 Шалгалтад өөрийнхөө оронд хүн оруулсан, бичиг баримтыг хуурамчаар үйлдэн хууран мэхлэхийг оролдсон тохиолдолд тухайн шалгуулагчийн бүртгүүлсэн болон өгсөн бүх шалгалтыг хүчингүй болгоно.

7 дугаар зүйл . Шалгалтын дүн мэдээ

7.1 Бүх шалгуулагчдын хариултын хуудсыг шалгагч машинаар засаж оноог гаргана.

7.2 Шалгалтын материал болон зөв хариултыг даалгаврын зөв хариултыг www.monicra.mn вебсайт хэсэгчилэн байрлуулахаас гадна эмхтгэл болгон хэвлүүлж болно.

7.3 Шалгалтын оноо, жагсаалтыг шалгалтын комиссын хурлаар хэлэлцүүлэн гишүүд танилцаж, гарын үсэг зурсны дараа www.mof.mn болон www.monicra.mn вебсайт байрлуулна.

7.4 Шалгуулагч шалгалтын дүн, оноог өөрийн бүртгэлийн дугаар болон нууц код ашиглан www.monicra.mn вебсайт-аас үзэж болно.

7.5 Шалгалтын нэгдсэн дүнг шалгалтын комисс хэлэлцэж баталсан өдрөөс 1 хоногийн дараа нийтэд мэдээлнэ.

8 дугаар зүйл. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалт, шалгалтын үнэлгээ

8.1 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад орохын өмнө иргэн санхүүгийн тайлан гаргах цогц бодлого, мэдээллийн технологи, ур чадвар, мэргэжлийн ёс зүйн сургалтанд заавал хамрагдсан байна.

8.2 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгоход дараах шалгалтыг тогтоосон хугацаанд өгсөн байна. Үүнд:

- Бизнесийн болон татварын эрх зүй	3.5 цаг
- Англи хэл	2.0 цаг
- Ахисан түвшний аудит ба баталгаажуулалт /АОУС/	3.5 цаг
- Санхүүгийн бүртгэл ба тайлагнал /СТОУС/	4.0 цаг
- Зардал, удирдлагын бүртгэл	4.0 цаг

8.3 Журмын 8.2.-т заасан шалгалтыг амжилттай өгч тэнцсэн иргэн мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг 2 жилийн хугацаагаар авч 3 дугаар хавсралтаар батлагдсан гэрчилгээг олгоно.

8.4 Өмнөх онуудад санхүү, зардал, удирдлагын бүртгэл болон нягтлан бодох бүртгэлийн дадлага гэсэн 2 шалгалтын аль нэгэнд нь тэнцэж хөнгөлөлт авсан иргэн нь 2013 оны 6-р сар хүртэлх хугацаанд тэнцээгүй үлдсэн шалгалтаа өгч болно.

8.5 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтын оноо тус бүр 75 ба түүнээс дээш тохиолдолд шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

8.6 Шалгалтын оноо нь 75 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн шалгалтын дүн 18 сарын хугацаанд хүчин төгөлдөр байна.

8.7 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалт өгснөөс хойш 6 сарын дараа дахин шалгалт өгөхийг зөвшөөрнө.

9 дүгээр зүйл. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах шалгалт, шалгалтын үнэлгээ

9.1 Мэргэшсэн нягтлан бодогчийн 2 жилийн эрх авсан иргэн нь дараах шалгалтыг тогтоосон хугацаанд өгсөн байна. Үүнд:

- Санхүүгийн менежмент
- Бизнесийн орчин
- Үнэт цаасны зах зээл

9.2 Журмын 9.1-т заасан шалгалтыг өгч тэнцсэн иргэнд Мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг 5 жилийн хугацаагаар олгоно.

9.3 Мэргэшсэн нягтлан бодогчийн 5 жилийн эрх авсан иргэн дараах шалгалт өгнө. Эрх олгогдсоноос хойш хоёр дахь жилд:

- Корпораци болон бизнесийн стратеги
- Эконометрик, статистик эдийн засгийн шинжилгээний аргууд

Эрх олгогдсоноос хойш тав дахь жилд:

- Удирдлагын зөвлөгөө өгөх үйлчилгээ
- Хөрөнгийн үнэлгээ
- Корпорацийн засаглал

9.4 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах сургалт, шалгалтын хугацаа гурван долоо хоногоос хэтрэхгүй хугацаагаар үргэлжилнэ.

9.5 Эрх сунгах сургалтын хөтөлбөрийн 70-аас доошгүй хувийг мэргэшсэн нягтлан бодогчид бие дааж судалсан байвал зохино.

9.6 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах сургалт, шалгалтын төлбөрийг ажилладаг байгууллага нь хариуцаж болно.

9.7 Журмын 9.3-д заасан шалгалтанд тэнцсэн бол 4 дүгээр хавсралтаар батлагдсан хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээг олгоно.

9.8 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх сунгах шалгалтын оноо 75 хувь ба түүнээс дээш тохиолдолд шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

9.9 Мэргэшсэн нягтлан бодогч нь эрх сунгах аль нэг шалгалтад хангалтгүй дүн авсан бол 12 сарын дотор 2 удаа давтан өгч болно. Энэ хугацаанд давтан шалгалт өгөөгүй бол тэнцээгүйд тооцно.

10 дугаар зүйл. МНБ-ийн гэрчилгээ олгох, хүчингүй болгох

10.1 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох, сунгах тухай шийдвэрийг шалгалтын комиссын мэдүүлснээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

10.2 Аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээ, хувийн тэмдгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгоно.

10.3 Мэргэшсэн нягтлан бодогчдод энэ журмын 3, 4 дүгээр хавсралтаар батлагдсан “мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээ”-г, “хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээ”-г монгол дээр тус тус олгоно.

10.4 Аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын дагуу дараагийн шатны шалгалтад тэнцээгүй, эсхүл хүндэтгэх шалтгаангүйгээр уг шалгалтад ороогүй мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хүчингүй болсонд тооцно.

10.5 Мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээнд бичигдсэн эрхийн хугацаа дуусмагц, түүний эрх нь дуусах бөгөөд энэ талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэр гарах хүртэл түдгэлзэх байдалд шилжинэ. Эрх нь түдгэлзсэн хугацаанд Мэргэшсэн нягтлан бодогчийн хуулиар олгогдсон эрх эдлэх, албан үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

10.6 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хүчингүй болгох саналыг институтээс санаачилж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

11 дүгээр зүйл . Шалгалтын өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх

11.1 Иргэдээс ирсэн шалгалттай холбоотой өргөдөл, гомдлыг шалгалтын комисс шийдвэрлэнэ.

11.2 Шалгуулагч шалгалтын дүн, оноотой санал нийлэхгүй байгаа болон даалгаврын хариулттай холбоотой өргөдлөө бичгээр гаргаж, шалгалтын дүн зарлагдсанаас хойш ажлын 3 өдөрт багтаан Шалгалтын комиссын даргад бичгээр ирүүлнэ.

11.3 Өргөдлийг ажлын 3 өдөрт багтаан шийдвэрлэж хариуг бичгээр өгнө.

11.4 Шалгалтын дүнтэй холбогдсон маргаан гарвал шалгалтын комиссын дарга хөндлөнгийн магадлах хэсэг томилон материалыг дахин шалгуулах бөгөөд тухайн магадлах хэсгийн дүгнэлт эцсийн шийдвэр болно.

11.5 Шалтгаанаа тодорхой заагаагүй болон буцах хаяггүй өргөдлийг хүлээн авахгүй болно.

Сангийн сайдын 2012 оны 15 дугаар
сарын 20-ны өдрийн 133 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

**Бусад орны мэргэшсэн нягтлан бодогчийн эрхтэй иргэнд
мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох журам**

1 дүгээр зүйл. Ерөнхий зүйл

1.1 Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн гадаад орны болон олон улсын мэргэжлийн байгууллагаас Монгол улсад болон гадаад оронд зохион байгуулсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтанд тэнцсэн иргэнд мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хугацаагүй олгоход энэ журмыг баримтална.

**2 дугаар зүйл. Гадаадын байгууллагаас Монгол улсад болон гадаад оронд
зохион байгуулсан мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтад тэнцсэн
иргэнд мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хугацаагүй олгох**

2.1. Аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 5 дахь заалтын дагуу мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хугацаагүй олгоход дараах нөхцлийг баримтална.

2.1.1 Гадаадын орны мэргэшсэн нягтлан бодогч нь шалгалтанд бүртгүүлэхдээ 1 дүгээр хавсралтаар батлагдсан журмын 2.5-т заасан баримт, материалын хамт тухайн мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгосон институт /байгууллага/-ийн жинхэнэ гишүүнийг баталсан сертификат, нотолгоог бүрдүүлнэ.


2.1.2 Шалгалтын хөтөлбөрт нь үнэлэлт өгөх замаар тухайн иргэний шалгалт өгсөн гадаад орны буюу олон улсын мэргэжлийн байгууллагын олгосон Мэргэшсэн нягтлан бодогчийн итгэмжлэлийг институт хүлээн зөвшөөрсөн байна.

2.2 Шалгалтын комисс тухайн иргэнээс бизнесийн болон татварын хуулиар англи болон монгол хэл дээр шалгалт авна.

2.3 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шалгалтын комиссын саналыг үндэслэн гадаадын иргэнд Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг олгох шийдвэр гаргана.

2.4 Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгогдсон гадаадын иргэнд энэ журмын 4 дүгээр хавсралтаар батлагдсан хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээг олгоно.

Сангийн сайдын 2012 оны ~~11~~ дугаар
сарын ~~30~~ ны өдрийн ~~11~~ дугаар тушаалын
3 дугаар хавсралт



Монгол улс
Мэргэшсэн нягтлан бодогчийн гэрчилгээ

Дугаар.....



Эцэг (эх)-ийн нэр

Нэр

Монгол улсын Аудитын тухай хуульд заасан бүх шаардлагыг хангаж, мэргэжлийн шалгалтад тэнцсэн тул Сангийн сайдыноныдугаар сарынөдрийн тоот тушаалаар Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгов.

Гэрчилгээонысарынөдөр хүртэл хүчинтэй.

Энэ гэрчилгээг эзэмшигч нь Мэргэшсэн нягтлан бодогчид хамаарах бүрэн эрхийг эдэлж, хариуцлагыг хүлээнэ.

Сангийн сайд

Улаанбаатар хот

.....оны.....сарын.....ны өдөр


Эрх сунгалт:

Сангийн сайдыноны.....дугаар сарынөдрийнтоот тушаалаароны.....сарын.....өдөр хүртэл эрхийг сунгав.

ММНБИ-ийн гүйцэтгэх захирал

.....оны.....сарын.....өдөр

Сангийн сайдын 2012 оны 28 дугаар
сарын 30-ны өдрийн 11 дугаар тушаалын
4 дүгээр хавсралт



МОНГОЛ УЛС
хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогчийн
ГЭРЧИЛГЭЭ



№.....

Эцэг/эх/-ийн нэр

Нэр

Монгол Улсын Аудитын тухай хуульд заасан бүх шаардлагыг хангасан тул мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийг хугацаагүйгээр олгов.

Энэхүү гэрчилгээг эзэмшигч нь Мэргэшсэн нягтлан бодогчид хамаарах бүрэн эрхийг эдэлж, хариуцлагыг хүлээнэ.

Гэрчилгээг олгосон шийдвэр:

Сангийн сайдын оны дугаар сарын-ны өдрийнтоот тушаал

Сангийн сайд

.....